




Орхон аймгийн ЗДТГазар

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2015 оны 03-р сарын 23-ны өдөр




1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дутуу, чанаргүй хийгдсэн зарим ажлын явц, гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргаж танилцуулах ажлыг эрчимжүүлэх:

- Биелэлт:Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу нэр бүхий 10 ажлыг шалган, цаашид авах арга хэмжээг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2015 оны А/35 дугаартай захирамжаар томилогдон, авах арга хэмжээг боловсруулан 03-р сарын 04-ний өдрийн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрийг гаргуулан ажиллаж байна. Зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 5-р хорооллын авто зам болон Бурхан багшийн сэрэг дүрийн гагнуур өнгөлгөө, бэхэлгээний ажилд Санхүүгийн хяналт аудитын албанаас дүгнэлт гаргаад байна.

**2. Баян-Өндөр сумын гэр
хорооллын зарим
гудамжинд инженерийн
шугам сүлжээ барих ажлын
зураг төсөл боловсруулах
ажлыг яаралтай зохион
байгуулах:**

- Биелэлт : Гэр хорооллын зарим багуудыг инженерийн шугам сүлжээнд ажлын зураг төсөл боловсруулах ажил судалгааныхаа шатанд явагдаж, техникийн нөхцөл, зургийн даалгавар боловсруулах ажил хийгдэж байна.



**3. Орон сууцны байруудын
оршин суугчдаас ирүүлсэн
байрны төлбөр нэмэгдсэн
талаарх гомдлуудыг судалж
хариуг өгөх:**

“Эрдэнэт Ус” ДТС ОНӨХК-иас холбогдох тайлбар, баримтыг гаргуулж судлаж иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Дулааны үнийн хувьд: Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 196 дугаар тогтоолоор 2014 оны 12-р сарын 05-ны өдрөөс эхлэн дулааны үнэ 13 хувиар нэмэгдсэн. Мөн 2014 оны 189 дугаар тогтоолын дагуу 2015 оны 02-р сарын 01-ний өдрөөс эхлэн орон сууцны айл өрхийн дулаан тооцох талбайг, орон сууцны болон сууцны бус талбайн нийлбэрээр тогтоож, төлбөрийг нэмэгдүүлэн тооцож байна.

Цахилгааны үнийн хувьд: Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор орон сууцанд оршин суугч айл өрх аж ахуй нэгж байгууллагын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс цахилгаан эрчим хүчний үнэ 9.8-13.0 хувиар нэмэгдсэн.

Хэрэглээний усны хувьд: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 12-р сарын 04-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор орон сууцанд оршин суугч айл өрх аж ахуй нэгж байгууллагын цэвэр усны үнэ 2015 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн 17-оос 32 хувиар нэмэгдсэн. Мөн айл өрх тогтмол 2200 төгрөгийн суурь үнэтэй болсон, аж ахуй нэгж байгууллагууд нь тоолуурын буюу оролтын шугамын голчоос хамааран суурь үнэ харилцан адилгүй тогтоогдсон байна.

4. Гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлуудын зураг төслийг боловсруулах ажлыг яаралтай зохион байгуулах талаар холбогдох газруудад үүрэг чиглэл өгөх :

- Биелэлт : Гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах ажлын зураг төсөв боловсруулалт 03-р сарын 23-ны өдөр дуусгахаар ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа



2015 ОНЫ 03-Р САРЫН 23